



САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

“20 МИНУТЫН ХОТ ХӨГЖЛИЙН ТӨВ”-ИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭН ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2025.12.

“20 МИНУТЫН ХОТ ХӨГЖЛИЙН ТӨВ”-ИЙН 2025 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2025.12.30

Нэг.Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, арга зүй

“20 минутын хот хөгжлийн төв”-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт өгч, удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж хүргүүлэх, удирдлагыг холбогдох мэдээллээр хангахад энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын ЗОРИЛГО оршино.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2025 оны “Журам батлах тухай” 43 дугаар тогтоолын 3-р хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ыг тус тус баримтална.

Хоёр.Танилцуулга

2024 оны Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнд Засгийн газрын тухай хуульд орсон өөрчлөлтөөр шинээр байгуулагдсан Засгийн газрын бүтцэд Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга гэж орж:

- хотын хэт төвлөрлийг сааруулах асуудал;
- нийгмийн үйлчилгээг 20 минутын дотор авах хүнд ээлтэй шинэ орчин, нөхцөлийг бүрдүүлэх бодлогын зохицуулалт;
- авто замын түгжрэлийг бууруулах асуудал;
- төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах асуудал;
- агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал,

гэсэн бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхлэхээр хуульчилж улмаар Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.1, 1.1.4-т заасан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 131 дүгээр тогтоолоор “Хөшгийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа”-г Монгол Улсын сайд, 20 минутын хот үндэсний хорооны эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулах “20 минутын хот хөгжлийн төв” болгосон.

20 минутын хот үндэсний хорооны даргын А/12 дугаартай тушаалаар “20 минутын хот хөгжлийн төв”-ийн дүрэм, бүтэц, орон тоо (4 хэлтэс, 35 хүний бүрэлдэхүүнтэйгээр), цалингийн сүлжээг анх баталж, хөгжлийн төвийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг тайлант оны 04 дүгээр сарын 21-ний өдөр Үндэсний хорооны даргаар батлуулсан байна.

Монгол Улсын Засгийн газар 2025 онд дахин шинээр зохион байгуулагдсантай холбоотойгоор Засгийн газрын тухай хуульд орсон өөрчлөлтөөр Засгийн газрын бүтцэд “үндэсний хороо”-д байхгүйгээр хуульчилсан бөгөөд Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны даргын эрхлэх асуудлууд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудалд шилжсэн.

Гурав.Хяналт-шинжилгээ, үнэлгээ

“20 минутын хот хөгжлийн төв”-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ тус хөгжлийн төвөөс ирүүлсэн төлөвлөгөө, түүний 83.14 хувиар үнэлж ирүүлсэн хэрэгжилтийн тайланг үндсэн материал болгон ашиглав.

Хөгжлийн төв нь 2025 онд:

- Төрийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд “Алсын хараа-2050” МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд 3 зорилтын 17 арга хэмжээг,
- “Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт арга хэмжээ”-ний хүрээнд 1 зорилтын 4 арга хэмжээг,
- “Хуулиар олгогдсон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 3 зорилтын 14 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд төлөвлөснөөс тайлант жилийн эцсийн байдлаар **76.81** хувьтай буюу “**Хангалттай**” гэж үнэлэгдлээ.

Үүнд: 85-аас дээш хувьтай хэрэгжсэн 19, 70-85 хүртэлх хувьтай хэрэгжсэн 5, 70 хүртэлх хувийн хэрэгжилттэй 10, Төлөвлөгөөний өөрчлөлтөөс үнэлэгдээгүй 1 арга хэмжээ байна.

Хүснэгт 1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн нэгдсэн товчоо /хувиар/

№	Ажил үйлчилгээ	Зорилт	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь				Биелэлт (хувиар)
				85-аас дээш	70-85 хүртэлх	70 хүртэлх	Хоцорч байгаа	
1	Төрийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд	3	17	6	3	7	1	60.29
2	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт арга хэмжээ	1	4	1	2	1	0	73.75
3	Хууль эрх зүй хүрээнд компанийн удирдлага, зохион байгуулалт, чадавхийг сайжруулах	3	14	12	0	2	0	92.26
	Нийт	7	35	19	5	10	1	76.81

Хүснэгт 2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний арга хэмжээний биелэлтийн дүн /хувиар/

Дугаар	Гүйцэтгэл	Дугаар	Гүйцэтгэл	Дугаар	Гүйцэтгэл	Дугаар	Гүйцэтгэл
0	1	0	1	0	1	0	1
I	60.29	1.2.7	100	2.1.2	100	3.2	100
1.1	50.00	1.2.8	50.00	2.1.3	75.00	3.2.1	100
1.1.1	50.00	1.2.9	100	2.1.4	70.00	3.2.2	100
1.1.2	100	1.2.10	-	III	92.26	3.3	100
1.1.3	0.00	1.2.11	80.00	3.1	84.52	3.3.1	100
1.2	67.73	1.2.12	30.00	3.1.1	66.67	3.3.2	100
1.2.1	30.00	1.3	65.00	3.1.2	100	3.3.3	100
1.2.2	70.00	1.3.1	30.00	3.1.3	100	3.3.4	100
1.2.3	70.00	1.3.2	100	3.1.4	35.00	3.3.5	100
1.2.4	30.00	II	73.75	3.1.5	100	БҮГД	76.81
1.2.5	100	2.1	73.75	3.1.6	90.00		
1.2.6	85.00	2.1.1	50.00	3.1.7	100		

Хүснэгт 3. Хөгжлийн төвийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт /хувиар/

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Зорилтод түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /ирүүлсэн тайлагналт/	Биелэлт /хувь/
1. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ				60.29
1.1. “20 минутын хот” үзэл баримтлалыг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх, боловсронгуй болгох				50.00
1.1.1	Хот байгуулалтын эрх зүйн орчны судалгаа хийж “20 МИНУТЫН ХОТ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ”-ын төслийг боловсруулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран гүйцэтгэнэ.	Үзэл баримтлалын төслийг иж бүрдлийн хамт боловсруулсан байна.	“20 минутын хот Үндэсний хороо”-ноос “20 минутын хот” үзэл баримтлалыг боловсруулж Засгийн газраар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барих ажлын хэсгийг УИХ-ын гишүүн Г.Лувсанжамцаар ахлуулан байгуулсан. Тус ажлын хэсгээс үзэл баримтлалын төсөл, холбогдох судалгаа, тооцоолол, хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг боловсруулж, Засгийн газар, УИХ-аар хэлэлцүүлэх бэлтгэл хангасан. Төслийг Үндэсний хороо болон ХББОСЯ-ны сайдад танилцуулж, Засгийн газарт өргөн барих бэлтгэл хангасан. Тоо: Үзэл баримтлалын төсөл-1 багц Дүрэм, журам-0.	50.00
1.1.2	Нийгмийн дэд бүтцийн хүртээмжийн хүрээнд иргэдийн өдөр тутамдаа авдаг нийгмийн үйлчилгээний нэр төрлийг суурьшлын бүсийн ялгаатай байдлаар үнэлэн	Судалгааны үр дүн, дүгнэлт дээр үндэслэн 20 минутын хот үзэл баримтлал болон хуулийн төсөлд санал боловсруулж өгнө.	Иргэдийн өдөр тутамдаа авдаг нийгмийн үйлчилгээг тодорхойлох судалгааны ажлыг гэрээгээр гүйцэтгүүлсэн. Тоо: Гэрээт судалгаа-1	100

	олон улсын жи- шигтэй харьцуу- лан тодорхойлох			
1.1.3	Нийтийн тээв- рийн төрлүүдэд тавигдах шаард- лага олон улсын норм, дүрэм, стандартыг суд- лан, Монгол Ул- сад нэвтрүүлэх талаар судалгаа хийх	Олон Улсын норм, стандартыг судалсан байна.	Дараах норм, стандартыг судалсан. -Трамвай /LRT/ болон тусгай замын автобус /BRT/ олон улсын туршлага, стандарт; -Дугуйн замын хүртээмжийг сайжруулах зорилгоор дугуйн замын олон улсын норм, стандарт; -МУ-д хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, журмуудыг гадны орнуудын дүрэм, журамтай харьцуулан судалж, - 20 минутын Үндэсний хороонд уламжилсан. Тойм судалгаа-1	0.00
1.2. Бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, зураг, төсөв, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах				67.73
1.2.1	Бүтээн байгуу- лалтын төслүү- дийн нэгдсэн ме- нежментийн зөв- лөх үйлчилгээний тендерт шалгар- сан гүйцэтгэгчтэй чиг үүргийн дагуу хамтран ажиллана.	Менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж эхэлнэ.	Тендерийн баримт бичиг, ажлын даалгаврыг батлуулж, 24 мега төслийн танилцуулга, багц тендерийн баримт бичиг боловсруулан цахим tender.gov.mn дээр 20MXYX/20240103002 дугаартай олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтын зарыг оруулсан. Ажлын даалгаврын хавсралт танилцуулга Тоо: /Монгол хэл-1, Англи хэл-1/ Тендерийн баримт бичиг-1 2025.07.03-ны өдөр шалгаруулалт явагдах төлөвтэй байсан ч, 2025 оны 07 сарын 23-ны өдөр хүртэл тендерийн хугацааг сунгасан. 2025 оны 07 сарын 09-ны өдөр төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн санхүүжилт нь хэмнэлтэд тооцогдож, тендерийг цуцалж, мэдэгдлийг цахим системд байршуулсан.	30.00
1.2.2	Автомашингүй гудамж - Авто зог- соолын техник эдийн засгийн үндэслэл, зураг, төсөв боловс- руулах (Улаанбаатар)	Төсөвлөсөн зураг төсвийн дагуу аж- лыг гүйцэтгэсэн байна.	“20 минутын хот Үндэсний хороо”-ноос зарласан тендерт шалгарсан “Татах хүч” ХХК-тай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажилласан. Энэ хүрээнд: - Нийслэл, дүүргийн холбогдох байгууллагуудад албан бичгээр хандаж шаардлагатай мэдээллийг авч суурь судалгаа, ТЭЗҮ-д тусгах, ажлын байршил тодорхойлох уулзалтууд хийхэд дэмжлэг үзүүлж ажилласан; - Зураг төслийн гүйцэтгэгч компанийн ирүүлсэн эхлэлийн болон суурь судалгааны тайланг шалгаж, нийт 3 удаа санал, зөвлөмж, мэдээлэл хүргүүлсэн. Ажлын зурагт хяналт тавьж, сайжруулалт хийхэд дэмжлэг үзүүлсэн;	70.00

			- Нийслэлийн мэргэжлийн зөвлөл, Барилга хөгжлийн төвийн мэргэжлийн зөвлөлөөр 73 байршилд суурь судалгаа, төлөвлөлтийн санал, ТЭЗҮ хэлэлцүүлэхэд оролцож, санал өгсөн. Мэргэжлийн зөвлөлийн хурлаар Архитектур төлөвлөлтийн даалгавар авч үүнд нийцүүлэн загвар зураг болон ажлын зураг боловсруулах, батлуулах ажил хүлээгдэж байна. Гүйцэтгэгч байгууллагаас гэрээний хугацааг сунгуулах хүсэлт гаргасан болно.	
1.2.3	Явган хүн, энгийн болон цахилгаан хөдөлгүүрт дугуйн зам, байгууламжийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв (Улаанбаатар)	Төсөвлөсөн зураг төсвийн дагуу ажлыг гүйцэтгэсэн байна.	“20 минутын хот Үндэсний хороо”-ноос зарласан тендерт шалгарсан “ТГТ” ХХК-д зөвлөн туслах, ажлын гүйцэтгэлийг хангуулах хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэсэн: - Зураг төслийн гүйцэтгэгч компанийн ирүүлсэн ажлын зурагт хяналт тавих, зөвшилцөх ажил явагдаж байна. Шалгарсан гүйцэтгэгч компанид санал, зөвлөмж, мэдээллийг хүргүүлсэн. Нийт 77 км байршилд суурь судалгаа, төлөвлөлтийн санал, ТЭЗҮ боловсруулан Барилга хөгжлийн төвийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн. Гүйцэтгэгч байгууллагаас гэрээний хугацааг сунгуулах хүсэлт гаргасан.	70.00
1.2.4	УБ хотын 2040 он хүртэлх хөгжлийн ЕТ-тэй холбогдуулан боловсруулах УБ хотын хэсэгчилсэн ЕТ боловсруулах ажлыг зохион байгуулах	Шалгарсан гүйцэтгэгчийн үйл ажиллагааны бүх үе шатны гүйцэтгэлд хяналт тавих, үйл ажиллагаанд чиг үүргийн хүрээнд хамтран ажиллана.	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах байршилд зургийн даалгаврыг Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар, Улаанбаатар хотын ерөнхий архитектортой зөвшилцөж, боловсруулах ажилд санал өгсөн. (Төвийн үйл ажиллагаанд хамааралгүй арга хэмжээ)	30.00
1.2.5	Нийслэлийн нийтийн тээврээр зорчигчийн ачаалал болон урсгалын оновчлолын судалгааны арга зүйгээр дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллах.	Шалгарсан гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх суурь судалгаа, оновчлолын аргазүйн зөвлөмж гаргаж өгсөн байх мөн бүх үе шатны гүйцэтгэлд үйл ажиллагаанд чиг үүргийн хүрээнд хамтран ажиллана.	1.“20 минутын хот Үндэсний хороо”-оос өгсөн чиглэлийн дагуу олон улсад хэрэгжиж буй “Улаан гэрлээр баруун эргэх” болон “Зогс тэмдэг”-н замын хөдөлгөөний дүрмийг Монгол улсад үр өгөөжтэй хэрэгжүүлж буй туршлага болон олон улсын замын хөдөлгөөнд дагаж мөрдөж буй дүрэм журмыг судалсан. 2.BRT болон Трамвайн Олон Улсын норм, стандарт авто замын хөдөлгөөнд хэрхэн оролцох талаар судалсан.	100

			3. Авто замын түгжрэлийн шалтгаан болон авах арга хэмжээнүүдийн талаар судалгаа хийж, дүнг нэгтгэсэн Тоо: Судалгаа -1 багц	
1.2.6	Улаанбаатар хотын авто замын ачаалалд нөлөөлж буй хүчин зүйлсийг судлаж, санал, зөвлөмж боловсруулах.	1 багц судалгаа хийгдэж, санал, зөвлөмж боловсруулагдсан байна.	УБ хотын 6 байршилд авто замын олон түвшний уулзварын ерөнхий мэдээлэл, ажлын даалгаварт санал өгсөн. 20 минутын хот Үндэсний хороо болон НЗДТГ-т мэдээлэл хүргүүлсэн. 6-н байршилд олон түвшний уулзвар болон нүхэн шулуун байх загвар зураглал боловсруулан харьцуулсан аргаар үзүүлэн боловсруулсан. Тоо: Судалгаа -1 багц	85.00
1.2.7	Нийслэлийн авто замын уулзваруудын шинэчлэлтэй холбоотойгоор инженерийн шугам сүлжээний байршлын болон шилжүүлэх судалгааг хийж санал боловсруулах.	1 багц судалгаа хийгдэж, санал, зөвлөмж боловсруулагдсан байна.	Төслийн танилцуулга, мэдээллийг боловсруулж, санал хүргүүлсэн. Цаашид төслийг хэрэгжүүлэх нарийвчилсан судалгаа хийсэн. Тоо: Судалгаа-1 багц	100
1.2.8	Нийгмийн үйлчилгээний хүрээнд сургууль цэцэрлэгийн чанар, хүртээмжийн судалгаа хийж, 2026 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барих сургууль цэцэрлэгийн тоог боловсруулах	1 багц судалгаа хийгдэж, санал, зөвлөмж боловсруулан Улсын төсөвт тусгуулахаар хүргүүлсэн байна.	-Нийслэлд 1970-1980 оны үед барьж байгуулсан сургууль, цэцэрлэг, нийгмийн үйлчилгээний хүртээмжийн талаар харьцуулсан судалгаа хийж, Боловсролын яамны Хөрөнгө оруулалтын газартай санал солилцсон. - Нийслэлийн хэмжээн дэх сургууль, цэцэрлэгийн нягтаршлыг судалж, зураглал гарган, "20 минутын хот Үндэсний хороо"-нд танилцуулсан. Тоо: Судалгаа- 1 багц	50.00
1.2.9	УБ хотод газар доогуурх худалдаа үйлчилгээний цогц байгууламжтай явган хүний гудамжийг барьж байгуулах нөхцөл боломжийн судалгаа	Суурь судалгаа хийгдэж байна.	Олон улсын судалгааны ажил үргэлжилж байна.Ажлын хүрээнд УБ хотод хийгдэж болох хэд хэдэн байршилд судалгаа хийж, Их тойруу орчимд орших томоохон худалдаа үйлчилгээний газрууд болон ачаалал ихтэй явган зорчигчдын хөдөлгөөний урсгал бүхий явган замын судалгаа хийсэн. /1ш/, Шинээр төлөвлөх боломжит газар доорх коридорын саналыг өмнө нь хийсэн төслүүдтэй уялдуулан боловсруулсан. /1ш/	100
1.2.10	Агаарын болон хөрсний бохирдол, хүрээлэн буй орчны бохирдлыг	Суурь судалгаа хийгдэж байна.	Агаарын бохирдлыг бууруулах "20 минутын хот Үндэсний хороо"-ны ажлын хэсгийн хуралд оролцож, ажлын явцын мэдээллийг цуглуулсан.	-

	бууруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хог хаягдлыг ялгах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах хэрэгжилтийг судлалгаа дүгнэлт гаргах, иргэд, байгууллагуудтай хамтран ажиллах.		20 минутын үндэсний хороо татан буугдсан холбогдуулан тус ажил нь төвийн үйл ажиллагаанд хамаарахгүй болсон.	
1.2.11	Ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг гадаад дотоод байгууллагуудын бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрүүдийн мэдээллийг цуглуулан нэгтгэж, судалгаа дүгнэлт гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх.		Нийслэлийн ЗДТГ-ын дэргэдэх харьяа байгууллагаас автозогсоол, явган хүний гудамж, дугуйн замын мэдээллийг албан бичгээр авсан. Дараах байгууллагуудаас мэдээлэл авч, мэдээллийн санг бүрдүүлэв. Дотоодын байгууллага: □ НЗДТГ-ын “Тогтвортой авто зам тээвэр төсөл”-н Улаанбаатар хотын зогсоолын менежментийн бодлогын бичиг баримт, □ Нийслэлийн бодлогын судалгаа, шинжилгээний төвөөс УБ хотын зогсоолын төслийг хэрэгжүүлэхээр судлагдсан байршлын мэдээлэл, □ Нэгдсэн төслүүдийн удирдах газраас УБ хотод хэрэгжүүлэх мега төслүүдийн мэдээлэл, □ Нийслэлийн замын хөгжлийн газраас Сэлбэ голыг дагасан автозам, дугуйн замын зураг төслийн мэдээлэл, □ Улаанбаатар хотын хөгжлийн корпорациас “Нийтийн эзэмшлийн 50 байршил дахь төлбөртэй зогсоолын менежментийг сайжруулах төсөл”-н мэдээлэл □ Нийслэлийн дугуйн зам, явган хүний замын 2025 оны төсвийн мэдээлэл □ Эдийн засгийн хөгжлийн яамнаас “Төр хувийн хэвшлийн түншлэлийн” журмын ерөнхий танилцуулга Гадаадын байгууллага: Yokohama Urban Solution Alliance (YUSA) Улаанбаатар хотод хот төлөвлөлтийн чиглэлээр дэмжлэг үзүүлэх санал, танилцуулга Япон Улсын зөвлөх үйлчилгээний Алмек компани: Монгол Улсад хурдацтай явагдаж буй хотжилтын асуудлаар хэрэгжүүлэх арга хэмжээний төсөл боловсруулах	80.00

			суурь судалгаа /Саналын танилцуулга/ Япон Улсын Газар, дэд бүтэц, тээвэр, аялал жуулчлын яам: - Төр хувийн хэвшлийн түншлэлээр орон сууцжуулалтын төслийг хэрэгжүүлэх боломж, кэйс судалгаа Мэдээллийн санд байршуулахад бэлэн дотоодын байгууллагуудаас цуглуулсан багц мэдээллийн тоо:7 Гадаадын байгууллагаас цуглуулсан багц мэдээллийн тоо:3	
1.2.12	Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймгийн ерөнхий архитекторуудтай хамтран орон нутгийн зэрэглэлтэй хотуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах		-Аймгуудын ерөнхий архитекторын чиг үүргийг хууль, эрх зүйн хүрээнд судалж, Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 37 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай ЗГ-ын тогтоолын төсөл, танилцуулгыг хамт боловсруулсан. -Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн тулгарч буй асуудал танилцуулга боловсруулсан. -Шинээр байгуулагдах хотуудын хилийн цэсийн одоогийн байдал болон хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хилийн заагийн судалгаа хийсэн. Тоо: Судалгаа- 1 багц	30.00
1.3. Төслийн зөвлөх үйлчилгээ, худалдан авалт зохион байгуулах				65.00
1.3.1	Бүтээн байгуулалтын төслүүдийн нэгдсэн менежментийн зөвлөх үйлчилгээ /Улаанбаатар/	Зөвлөх үйлчилгээ авсан байна.	-Бүтээн байгуулалтын төслүүдийн нэгдсэн менежментийн зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврын англи хувилбарыг хийж, төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулсан; Менежментийн зөвлөх үйлчилгээний тендэр / 50 тэрбум ажлын бүтэц, задаргааг гаргасан / Тендэр цуцлагдсан/	30.00
1.3.2	Бусдаар гүйцэтгүүлэх зөвлөх үйлчилгээ	Зөвлөх үйлчилгээ авсан байна.	Тайлант хугацанд 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 3 зөвлөх үйлчилгээний ажлыг бусдаар гүйцэтгүүлсэн. Үүнд: -Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн талаарх АХБ-ны сургалт-2 удаа (Гэрээ дүгнэсэн) -Хуулийн зөвлөх үйлчилгээ (Гэрээ дүгнэсэн) -20 минутын хот үзэл баримтлалын төсөл боловсруулах гэрээт ажил / гэрээ дүгнэсэн/ Тоо: Зөвлөх үйлчилгээ-3	100

2. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ (СУДАЛГАА, МЭДЭЭЛЛИЙН ХАНГАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ)				73.75
2.1. Судалгаа, төлөвлөлт хийх, 20 минутын хот концепц, бүтээн байгуулалтын мэдээллийг олон нийтэд хүргэх				73.75
2.1.1	20 минутын хотыг олон нийт, хөрөнгө оруулагчдад сурталчилан таниулах зорилгоор контент бүтээх төслийг эхлүүлэх.	Контентийг олон нийтийн сүлжээнд байршуулсан байна.	20 минутын хотын үзэл баримтлалыг Засгийн газарт танилцуулахтай холбогдуулан үзэл баримтлалын видео болон хэвлэмэл танилцуулга, төвийн танилцуулгыг тус тус бэлтгэсэн.	50.00
2.1.2	Тусгай замын автобус /BRT/ төслийн танилцуулга бэлтгэх, боловсруулах	Гадаад тодоодын хөрөнгө оруулагч, иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад сурталчилан таниулна.	Тусгай замын автобусын танилцуулгыг бэлтгэж, 20 минутын хот үндэсний хорооны хуралд танилцуулсан. Тоо: Танилцуулга-1	100
2.1.3	Түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд хөдөлгөөн зохицуулалт (гэрэл дохио зохицуулалт, түгээлт, хүргэлтийн үйлчилгээний цагийн менежмент) ын судалгаа хийж санал боловсруулах	Судалгааны үр дүнд суурилсан саналыг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.	-Олон улсын стандарт, норм дүрмийг судлан Улаанбаатар хотод явган зам сүлжээний трасс, төвийн хэсгийн бага тойруу доторх орон зайд боломжит байршлын судалгаа боловсруулан бага тойрууд 8 блок бүхий бүсчлэлд хуваан бүс бүрд явган орон зайн төлөвлөлт, 3D орон зайн зураглал, харьцуулсан зураглал бэлтгэн багц танилцуулга боловсруулж, 20 минутын хот үндэсний хороонд хүргүүлсэн. Тоо: Судалгааны багц танилцуулга:1 -Авто замын уулзварын нэвтрэлтийг сайжруулах зорилго бүхий "СТОП" тэмдэг байрлуулах замуудын дрон судалгаа хийж УЛААН ГЭРЭЛ-ээр саадыг өнгөрөөд баруун эргэх талаар Үндэсний хороон дээр уулзалт хийж, холбогдох контентыг боловсруулсан. Мөн нийслэлийн түгжрэлийг бууруулах ажлын хэсэгт танилцуулж, нийт 11 уулзварт саадыг өнгөрөөж баруун эргэх зохицуулалтыг хийсэн. Тоо: Судалгаа-2 багц Орон зайн зураглал-1 багц, Контент-1	75.00
2.1.4	20 минутын хотын стандарт үйлчилгээний хүрээнд голуудыг түшиглэсэн амралтын бүсийг бий болгох байршлын судалгаа хийж төлөвлөлт гаргах	Амралтын бүсийн байршлыг тодорхойлон загвар зураг гаргасан байна.	Улиастайн голын концепц төлөвлөлтийг боловсруулж, Японы улсын Газар, дэд бүтэц, тээврийн яамны төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн саналыг танилцуулж, загвар зураг гаргасан. Тоо: Судалгаа, төлөвлөлт-1 Санал -1	70.00

3. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ (ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ, БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ)			92.26
3.1. Байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хэвийн үйл ажиллагааг хангах			84.52
3.1.1	Байгууллагын үйл ажиллагааны стратеги төлөвлөлт, дотоод үйл ажиллагааны удирдлага, хяналтын системийг боловсронгуй болгох,	Байгууллагын стратегийн зорилго, зорилт, дотоод бүтцийн нэгжүүдийн чиг үүрэг, удирдлага, хяналтын систем тодорхой болж, холбогдох баримт бичиг, цахим системүүдийг нэвтрүүлсэн байна.	- Төвийн үйл ажиллагаанд 2025 оны 06 сараас ERP системийг нэвтрүүлж эхэлсэн. Тус системд ажилтнуудыг тоон гарын үсгээр бүртгэж, албан бичгийн хэвлэмэл хуудсыг баталгаажуулж, цахимаар албан бичиг явуулах бэлтгэл хангасан. ERP-mongolia системээр нийт 40 албан бичиг хүлээн авч шийдвэрлэсэн. -Цаг бүртгэлийн төхөөрөмж суурилуулан 2025 оны 06 сараас ажилтнуудын цаг бүртгэлийг царай таних төхөөрөмжөөр бүртгэж эхэлсэн. - Тайлант хугацаанд төвийн бүтэц, зохион байгуулалт 2 удаа өөрчлөгдсөн. Үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө боловсруулалтын шатанд. Тоо: /Стратеги төлөвлөгөө-0, Цаг бүртгэлийн систем-1, ERP систем-1/
3.1.2	Байгууллагын дүрэм, дотоод үйл ажиллагааг зохицуулах журам, заавруудыг шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг хангуулах	Шаардлагатай дүрэм, журмыг шинэчлэн, нэмэлт өөрчлөлт оруулж баталгаажуулсан байна.	I. ЗГ-ын 2025 оны 131-р тогтоол, 20 минутын хот-Үндэсний хорооны сайдын А/12-р тушаалыг хэрэгжүүлэх хүрээнд дараах баримт бичгүүдийг боловсруулж батлуулсан. Үүнд: - Төвийн дүрэм (шинээр) - Төвийн дотоод бүтцийн нэгжүүдийн чиг үүрэг (шинээр) - Хөдөлмөрийн дотоод журам(шинээр) - Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтууд (нийт 29 ажлын байранд шинээр) II. 2025 оны 06 сард байгууллагын харьяалал өөрчлөгдсөн, ХББОСЯ-ны сайдын 2025 оны 222-р тушаалаар бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан дараах баримт бичгүүдийг шинээр болон шинэчлэн боловсруулсан.Үүнд: - “Хөдөлмөрийн дотоод журам” /шинэчилсэн/ - “Ажилтан сонгон шалгаруулах журам” /шинээр/ - Ажлын байрны тодорхойлолтууд-28 (шинээр-7, шинэчлэн баталсан-7, дутуу-8) - Ёс зүйн дэд хороог /шинэчилсэн/ - Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс /шинээр/ - Өмч хамгаалах байнгын зөвлөл /шинээр/ Тоо: Дүрэм, журам- 5, АБТ-43 Шийдвэр-3

3.1.3	Иргэн болон хуулийн этгээдтэй гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих	Гэрээний төслийг хянан баталгаажуулж, гэрээний бүртгэлийг хийж, хэрэгжилтэд хяналт тавьсан байна.	-2025.01.31-2025.02.10 хооронд газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн АХБ-ны сургалт-2 удаа (гэрээ дүгнэсэн) -ЗГАБ-тай Автомашины түрээсийн гэрээ байгуулж, 2025.06.01 нээр цуцалсан. -Хуулийн зөвлөх үйлчилгээний гэрээ (гэрээ дүгнэсэн) -20 минутын хот үзэл баримтлалын төсөл боловсруулах гэрээ /гэрээ дүгнэсэн/ -НИК ХХК-тай шатахууны гэрээ /2026.03.11 хүртэл/ -Урсгал засварын ажлын гэрээ /гэрээ дүгнэсэн/ -“Шинэ зуунмод хотын зарим бүсэд байгаль орчны ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийлгэх ХХББАХЗ/20240201011 гэрээний хугацаа сунгах нэмэлт гэрээ”-г дүгнэж акт боловсруулж албажуулсан. -ЭКО пропертиз ХХК-тай түрээсийн гэрээг 07 сард шинэчлэн байгуулж, 11.01-нээр гэрээ цуцалж дүгнэсэн. Түрээсийн байрны гэрээг дуусгаж, тооцоо нийлсэн акт үйлдэж, албажуулсан. -ХББОСЯ-ны сайдын 222 тушаалын хүрээнд ажлаас чөлөөлөгдсөн-8, тэтгэвэр тогтоолгосон-1, нийт 9 хүний хөдөлмөрийн гэрээг цуцалж, дотоод шилжилт хөдөлгөөн хийгдсэн 10, шинээр ажилд томилогдсон 11 хүнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулан, хүний нөөцийн бүртгэл хийж, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.	100
3.1.4	Архив, албан хэрэг хөтлөлтийн журам боловсруулж батлуулах, архивын сан хөмрөг үүсгэх	Байгууллагын бүтэц чиг үүрэгт өөрчлөлт орвол 2025 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн батлуулна. 2025 оны хөтөлж дууссан баримтыг хадгаламжийн нэгж үүсгэн архивласан байна.	-ХХББЗ-ны архивын материалыг архив, албан хэрэг хөтлөлтийн журмын дагуу цэгцэлж, Улсын архивт хүлээлгэн өгөх бэлтгэл хангуулан ажиллаж байна. -Байгууллагын 2025 оны баримт материалыг цэгцэлж, архивын нэгж болгон хадгалах ажлыг зохион байгуулж ажилласан. -Архив, албан хэрэг хөтлөх журмын дагуу 2025 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалт гарган, сан хөмрөг үүсгэн ажиллаж байна. Тоо: Журам-1 (Хөтлөх хэргийн жагсаалт)	35.00
3.1.5	2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангуулах, биелэлтийг тайлагнах	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна. Биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган	Төвийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг ажилтан, хэлтэс тус бүрээр авч нэгтгэн боловсруулж биелэлтийг хагас, бүтэн жилээр авч хянуулж, удирдлага болон дээд байгууллагад тайлагнасан. Тоо: Төлөвлөгөө-1, Тайлан-2	100

		тайлагнасан байна.		
3.1.6	Байгууллагын ирсэн, явсан бичиг, өргөдөл, гомдлын бүртгэл хөтлөн, хяналт тавих,	Цахим болон цаасан хэлбэрээр бүртгэл хөтлөн хуулийн хугацаанд холбогдох хариуг өгч ажилласан байна.	Төвд ирсэн 82, явсан 208 нийт 290 албан бичгийг дугаарын дагуу цахим болон цаасан хэлбэрээр хадгалж, бичиг хэргийн зааврын дагуу албажуулан эмхэтгэж, холбогдох байгууллагуудад илгээж, хүргүүлэх ажлыг өдөр тутам гүйцэтгэж ажилласан.	90.00
3.1.7	Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын захиргаанаас эд хөрөнгө хүлээн авч акт үйлдэх, эд хөрөнгийн тооллого хийж өмч хөрөнгийг бүртгэх,	Засгийн газрын 2025 оны 131-р тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд БХБЯ-ны сайдын багцаас ХХББАХЗ-ны эд хөрөнгийг 20 минутын хот хөгжлийн төвийн балансад шилжүүлэн авч, тооллого хийсэн байна.	-Үндэсний хорооны даргын 2025.04.17-ны А/17 тушаалаар хөрөнгө хүлээн авах ажлын хэсэг байгуулагдаж, 2024 оны жилийн эцсийн байдлаар БХБЯ-ны сайдын багцаас “20 минутын хот Үндэсний хороо”-ны сайдын багцад шилжүүлсэн. Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын захиргааны эд хөрөнгийг хүлээн авч акт үйлдэн баталгаажуулсан. ТӨБЗГ-т хүсэлт гарган Засгийн газрын 2025 оны 131 дүгээр тогтоолоор “Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа” нэршлийг “20 минутын хот хөгжлийн төв” болгон өөрчилсөнтэй холбогдуулан ТӨБЗГ-ын өмчийн бүртгэлийн системд нэр өөрчлөх, өр авлага барагдуулах, балансад бүртгэлтэй үндсэн болон эргэлтийн хөрөнгийг балсансаас балансад шилжүүлүүлэх ажлыг зохион байгуулсан. -ХББОСЯ-ны сайдын 222 тушаалын шинэ бүтэц орон тооны хүрээнд Төвийн эд хөрөнгийн тооллогыг эцсийн байдлаар дахин тоолж, бүртгэлжүүлсэн. Тоо: Тооллого- 2 удаа Эд хөрөнгө хүлээлцсэн акт-1	100
3.2. Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт татах, гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх				100
3.2.1	Холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд гадаад орнууд, олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөртэй хамтын ажиллагаа эхлүүлэх, хөгжүүлэх чиглэлээр ажиллах.	Гадаад улс орон болон олон улсын байгууллагатай харилцаа, хамтын ажиллагаа эхлүүлсэн байна.	Япон улсын Дэд бүтэцийн яамтай хамтын ажиллагааг эхлүүлж төр хувийн хэвшлийн түншлэлээр Улаанбаатар хотод хэрэгжүүлж болох төсөл хөтөлбөрт Япон улсын хөрөнгө оруулагчдыг хамруулах чиглэлээр холбоо тогтоон, ажилласан. Герман улсын PTV Visum групп-тэй харилцаа тогтоож, тээврийн эрэлтийн хөдөлгөөний симуляцийг тооцох сургалтад нийт 3 удаа хамрагдсан.	100
3.2.2	Олон улсын хэмжээнд болон	5-10 арга хэмжээний үеэр	Нийт 5 удаагын уулзалт, хэлэлцүүлэг, арга хэмжээнд байгууллагын үйл	100

	дотоодод зохион байгуулагдах төрөл бүрийн худалдаа, хөрөнгө оруулалтын олон улсын арга хэмжээний үеэр байгууллагын үйл ажиллагааг таниулан сурталчлах	байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан байна.	ажиллагааг таниулах, сурталчилж ажилласан. Тухайлбал: -“Зөөлөн хот” олон улсын фестиваль зохион байгуулахад хамтран оролцсон; -“20 минутын хот Үндэсний хороо”-той хамтран “Говийн бүсийн зөвлөгөөн” 3Г-ын өргөтгөсөн хурлын бэлтгэл хангах, зохион байгуулахад оролцсон; - Монгол Япон хүний нөөцийн хөгжлийн төв /2025.08.15/ Японы Газар, дэд бүтэц, зам тээвэр, аялал жуулчлалын яам, ЖАЙКА-Монгол улсын хот байгуулалт болон дэд бүтцийн салбарын ТХХТ-ийн төслийн хамтын ажиллагааны семинарт оролцсон. Тоо: Арга хэмжээ-5	
3.3. Санхүү, тайлан, бүртгэлийг хууль тогтоомжид нийцүүлэн явуулж, эд хөрөнгө, техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээг сайжруулах				100
3.3.1	Байгууллагын 2026 оны төсвийг батлуулж, 2025 оны батлагдсан төсвийн хэрэгжилтийг ханган ажиллах	Хуулийн хугацаанд 2025 оны төсвийн санал, 2026, 2027 оны төсвийн төсөөллийг боловсруулж, удирдлагад танилцуулж, БХБЯ, СЯ, ЭЗХЯаманд хүргүүлсэн байна.	-Төвийн 2025 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, тухай бүр холбогдох байгууллагад тайлагнаж ажилласан. -Төвийн 2026 оны төсвийн хүрээг гаргаж Сангийн яаманд хүргүүлсэн. -2026 оны урсгал төсвийн төсөөллийн саналыг боловсруулан ХББОСЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын газарт хүргүүлсэн.	100
3.3.2	Шилэн дансны тухай хуулийн дагуу байгууллагын мэдээллийг тухай бүрт оруулах, үнэн зөв, ил тод байдлыг хангаж ажиллах.	Шилэн дансны шинэчлэгдэж буй системд байгууллагын мэдээллийг байршуулж мэдээллийг тухай бүр баталгаажуулсан байна.	Төвийн холбогдох мэдээллийг хуульд заасан хугацаанд цахим системд байршуулсан. Тоо: Шилэн дансны цахим системд 2025 оны 1,2,3,4,5-р сарын төсөв, гүйцэтгэлийн цэсэд 27, хөрөнгө оруулалт, тендэр худалдан авалт цэсэд 17, бусад цэсэд 31 мэдээллийг хугацаанд нь байршуулж ил тод олгосон.	100
3.3.3	Эд хөрөнгө, техник, тоног төхөөрөмжийн бүртгэл, хангалт, ашиглалттай холбоотой нийтлэг үйл ажиллагааг зохион байгуулах.	Хуулийн хүрээнд эд хөрөнгийн тооллого хийнэ. Эд хөрөнгийн ашиглалт, бүртгэлийн мэдээллийг ТӨБЗГазарт хүргүүлж, Өмч эзэмшүүлэх гэрээг дүгнүүлсэн байна.	2025 онд нийт 180, 295,962.17 төгрөгийн эд хөрөнгийн биет тооллого хийгдэж баримтжуулсан. 2025 оны үндсэн эд хөрөнгө, тавилга, тоног төхөөрөмж техник хэрэгслийн тооллого хийж, кодлон бүртгэж, umch.sgov.mn программд бүртгэлтэй байгаа үндсэн эд хөрөнгийн тулгалт хийгдсэн. Компьютер тоног төхөөрөмж, сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангаж, доголдолыг тухай бүрт арилгаж, шинэ орсон албан хаагчдыг шаардлагатай компьютер тоног төхөөрөмж, программ хангамжаар хангаж ажилласан.	100

			Нийтлэг үйл ажиллагааны хүрээнд төсвийн хэмнэлтээр өмнөх түрээсийн байрнаас гарч, ХББОСЯ-ны байранд Төвийг нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааг 11 сард зохион байгуулсан.	
3.3.4	Санхүүгийн тайлан, балансыг хууль тогтоомж, дүрэм журмын дагуу үнэн зөв гаргаж аудитын дүгнэлтийн хамт холбогдох газарт хүргүүлэх.	Санхүүгийн байдлын иж бүрэн тайлан, Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан, Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татварын тайланг тус тус хуулийн хугацаанд баталгаажуулсан байна.	Санхүүгийн иж бүрэн тайлан, төсвийн гүйцэтгэл, НДШ-ийн тайлан, хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгах албан татварын тайланг хуулийн хугацаанд баталгаажуулсан. 2024 оны Үндэсний аудитын газрын хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгасан тайлбар мэдээллийг Үндэсний аудитын газар, ХББОСЯ-нд хүргүүлсэн. 2025 оны хагас жилийн Үндэсний аудитын шалгалтаар 4 зөвлөмж гарсан, зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажилласан.	100
3.3.5	Байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим системээр төлөвлөх, батлуулах, тайлагнах.	Хуулийн хүрээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж, хуулийн хугацаанд төлөвлөж, тайлагнаж ажилласан байна.	Байгууллагын 2025 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж төлөвлөгөөний дагуу худалдан авалтыг зохион байгуулж гүйцэтгэлийг хугацаанд нь тайлагнасан. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу дараах тендэрүүдийг нээлттэй зарласан боловч тодорхой шалтгааны улмаас цуцлагдсан.	100
БҮГД				76.81



Хүснэгт 4: Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ХШҮ хийсэн байдал

№	Заалт	нэгж	Шал.Үз	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин Шал.Үз-ээр	Гүйцэтгэл /Шал.Үз-ээр/	Гүйцэтгэл /Арга Хэмжээ/	Ирүүлсэн үнэлгээ	Тайлбар
	1	3	4	5	6	7	8	9	10	12
I	ЗОРИЛГО 1: ӨРИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД: /Алсын хараа-2050 МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого, МУ-ын ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Шинэ сэргэлтийн бодлого/									
0	1.1	"20 минутын хот" үзэл баримтлалыг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх, боловсрнгуй болгох								
1	1.1.1	Үзэл баримтлалын төсөл	Тоо	0	1	1	100	50.00	70.00	2024.9.2 №01 УИХ гишүүн Г.Лувсанжамц ахалсан ажлын хэсэг, үзэл баримтлалын анхны хувилбар боловсруулсан
		Дүрэм, журам	Тоо	0	2	0	0			үзэл баримтлалтай холбоотой ямар нэгэн дүрэм, журмын төсөл боловсруулсан баримт, мэдээлэл байхгүй, тайлагнаагүй
2	1.1.2	Судалгаа, дүгнэлтийн багц	Тоо	0	1	1	100	100.00	100.00	2025.02.24 №Г/25-04 гэрээ И Эм Эс Консалтинг ХХК 96 хуудас тайлан-legal consulting
3	1.1.3	Судалгаа, дүгнэлтийн багц	Тоо	0	1	0	0	0	50.00	ОУ-ын ямар нэртэй стандарт норм судалсан нь тодорхойгүй, 2024 онд хийсэн трамбай, тусгай замын нийтийн тээврийн талаарх танилцуулгаар тайлагнасан. Зөрүүтэй тайлагнасан
	1.2	Бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, зураг, төсөв, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах								
4	1.2.1	Менехментийн төлвлөгөө	Тоо	0	1	0.3	30	30.00	-	Тендер зарласан. Гүйцэтгэгч шалгараагүй. Санхүүжилт татагдсан. Менехментийн төлөвлөгөө боловсрогдоогүй
5	1.2.2	Батлагдсан зураг төсөв	Багц	0	1	0.7	70	70.00	100.00	Зураг төсөл эцсийн байдлаар хүлээн аваагүй, захиалагчийн хяналт хий ажлыг БХТ-тэй хамтран хийхээр байгаа боловч захиалагчийн хяналт хийснийг батлах ямар нэгэн баримт үйлддэггүй нь захиалагчийн



ХОТ БАЙГУУЛАЛТ,
БАРИЛГА, ОРОН
СУУЦУУЛАЛТЫН ЯАМ

										хяналтыг хэрхэн хэрэгжүүлдэг тодорхойгүй, хангалтгүй байна.	нь
6	1.2.3	Батлагдсан зураг төсөв	Багц	0	1	0.7	70	70.00	100.00	Зураг төсөл эцсийн байдлаар хүлээн аваагүй, захиалагчийн хяналт хэрэгжүүлэхэд БХТ-тэй хамтран хийж байгаа.	
7	1.2.4	ХэсТөл	Багц	0	4	1.2	30	30.00	-	Хэсэгчилсэн төлөвлөгөөний даалгаварт санал өгсөн. Төвийн үйл ажиллагаанд хамааралгүй ажил гэж тайлагнасан. Төвийн зорилго хот байгуулалтын үйл ажиллагаанд 20 минутын үзэл баримтлал, хот төлөвлөлтийн стандартыг тусгах мөрдүүлэх бөгөөд энэхүү зорилт нь үндсэн үйл ажиллагаанд хамааралтай бөгөөд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил болно. хангалттай ажил зохион байгуулаагүй. санаачлага гаргаагүй байна	
8	1.2.5	Судалгаа	Багц	0	1	1	100	100.00	100.00	2 төрлийн судалгаа хийсэн танилцуулга ирүүлсэн. (Тамбай, баруун эргэх зохицуулалт)	
9	1.2.6	Судалгаа	Багц	0	1	0.85	85	85.00	100.00	Авто замын ачаалалын нөлөөллийг тодорхойлсон судалгаа хийгдээгүй. 8 уулзварын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх санал боловсруулсан байна	
10	1.2.7	Судалгаа	Багц	0	1	1	100	100.00	100.00	ИДБ-ийн мэдээлэл цуглуусан. Уулзваруудыг шинэчлэх үеийн төвөгшлийг гаргасан танилцуулга бэлтгэсэн байна	
11	1.2.8	Судалгаа	Багц	0	1	0.5	50	50.00	70.00	Одоо байгаа ИДБ-ийн барилгын байршлаар судалгаа хийсэн. (өмнө хийгдсэн судалгаануудаас юугаар ялгаатай вэ?) хот төлөвлөлтийн нормоор, эсвэл нягтаршилаар, хүн амаар, зорчих зайн хэмжээ, хүчин чадал гэх мэт ямар талаар өмнө хийгдсэн судалгаануудаас ялгаатай, үр дүнтэй судалгаа хийгдсэн нь тодорхой бус байна	
12	1.2.9	Судалгаа	Багц	0	1	1	100	100.00	100.00	Газар доорхи үйлчилгээтэй явган гудамж байгуулах судалгаа хийж төсөөллийн загвар боловсруулсан	



ХОТ БАЙГУУЛАЛТ,
БАРИЛГА, ОРОН
СУУЦУУЛАЛТЫН ЯАМ

13	1.2.10	Судалгаа	Багц	0	1		0	-	-	Эрхлэх асуудлаас хасагдсан үйл ажиллагаа хийгдээгүй тул үнэлгээнээс хасав
14	1.2.11			0	1	0.8	80	80.00	100.00	9 газар, байгууллагаас мэдээлэл цуглуусан. Мэдээллийн санг ямар байдлаар бүрдүүлсэн. Цахимд оруулсан эсэх тодорхойгүй байна. Арга хэмжээг илэрхийлэх шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж тодорхойгүй
15	1.2.12			0	1	0.3	30	30.00	50.00	Тодорхой арга хэмжээ аваагүй, 7 байршилд газрын зурагт тэмдэглэсэн, Арга хэмжээг илэрхийлэх шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж тодорхойгүй
	1.3	Төслийн зөвлөх үйлчилгээ, худалдан авалт зохион байгуулах						65.00	50.00	
16	1.3.1	Авсан зөвлөх үйлчилгээ	Тоо	0	1	0.3	30	30.00	-	Тендер зарласан. Гүйцэтгэгч шалгараагүй. Санхүүжилт татагдсан.
17	1.3.2	Авсан зөвлөх үйлчилгээ	Тоо	0	1	1	100	100.00	100.00	2025 онд 3 төрлийн зөвлөх үйлчилгээ авсан. Арга хэмжээ нь бусад арга хэмжээтэй давхардсан.
II	СУДАЛГАА, МЭДЭЭЛЛИЙН ХАНГАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ									
	2.1	Судалгаа, төлөвлөлт хийх, 20 минутын хот концепц, бүтээн байгуулалтын мэдээллийг олон нийтэд хүргэх						73.75	100	
18	2.1.1	Олон нийтийн сүлжээнд оруулсан контент	Тоо	0	1	0.5	50	50.00	100.00	контент бэлтгэсэн боловч нийтийн цахим системээр цацаагүй байна.
19	2.1.2	Танилцуулгын хэвлэл	Багц	0	1	1	100	100.00	100.00	BRT танилцуулга бэлтгэсэн. Энэ арга хэмжээгээр 1.1.3 арга хэмжээг давхар оруулж тайлагнасан
20	2.1.3	Танилцуулгын хэвлэл	Багц	0	2	1.5	75	75.00	100.00	Гэрлэн дохиогүй Баруун эргэх танилцуулга хийгдсэн. Шалгуур үзүүлэлт, зорилтод түвшин хоорондоо уялдаагүй байгаа тул зорилтод түвшингээр хэрэгжилтийг үнэлсэн. Энэ арга хэмжээгээр 1.2.5 арга хэмжээг давхар оруулж тайлагнасан

ХОТ БАЙГУУЛАЛТ,
БАРИЛГА, ОРОН
СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ

21	2.1.4	Судалгаа	Багц	0	1	0.7	70	70.00	100.00	Арга хэмжээтэй зөрүүтэй мэдээлэл оруулсан. "Улиастай гол дагуух дугуйн замын трасс" танилцуулга бэлтгэсэн байна. Арга хэмжээ нь Гол түшиглэсэн амралтын бүс бий болгох байршлын судалгаа хийхээр байна.
III	ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ, БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ								97.86	
3.1	Байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хэвийн үйл ажиллагааг хангах								95.71	
22	3.1.1	Стратеги төлөвлөгөө	Тоо	0	1	0	0	66.67	70.00	Стратеги төлөвлөгөөг боловсруулсан баримт байхгүй
		Бүртгэлийн систем	Тоо	0	1	1	100			Бүртгэлийн царай таних төхөөрөмжтэй
		ERP систем	Тоо	0	1	1	100			ERP системд бүртгэлтэй байна
23	3.1.2	Шинэчилсэн дүрэм, журам	Тоо	0	6	6	100	100.00	100.00	Хөгжлийн төвийн захирлын тушаалаар дотоод дүрэм журам 5 батлагдсан
24	3.1.3	Баталгаажсан/ бүртгэсэн гэрээ	Тоо	0	7	7	100	100.00	100.00	7 хуулийн этгээдтэй, 21 хүнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулсан байна
		Гэрээний хэрэгжилт	%	0	100	100	100			9 хүний хөдөлмөрийн гэрээг цуцалж, хуулийн этгээдтэй байгуулсан 7 гэрээг дүгнэсэн
25	3.1.4	Журам	Тоо	0	1	0	0	35.00	100.00	Архивын дотоод журам боловсруулсан эсэх тодорхойгүй
		Архивын хөмрөг	Тоо	0	1	0.7	70			Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг нотлох баримт ирүүлээгүй, ирүүлсэн баримт нь албан хаагчид дотооддоо ажил хүлээлцэх үед мэдээлэл, файл хүлээлцсэн нотломж байна. Архивын материалд хэдэн төрлийн ямар баримтыг архивлаж, хадгаламжид авсан нь тодорхойгүй байна.
26	3.1.5	Төлөвлөгөө	Тоо	0	1	1	100	100.00	100.00	Гүйцэтгэлийн төлөвлөгөө 2025.04 сард батлуулсан
		Тайлан	Тоо	0	2	2	100			Тайлагнасан
27	3.1.6	Албан бичгийн шийдвэрлэлт	%	0	100	90	90	90.00	100.00	Албан бичгийн шийдвэрлэлтийн талаар тайлагнаагүй



ХОТ БАЙГУУЛАЛТ,
БАРИЛГА, ОРОН
СУУЦУУЛАЛТЫН ЯАМ

28	3.1.7	Тооллого хүлээлцсэн акт	Тоо	0	2	2	2	100	100.00	100.00	2025.06.24 №А/17, 2025.11.07 №А/28 ХХББАХЗ-аас 20МХҮХ-нд эд хөрөнгө шилжүүлсэн тэмдэглэл 2025.04.18
	3.2	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт татах, гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх	Тоо	0	1	1	1	100	100.00	100.00	
29	3.2.1	Хамтын ажиллагаа О/У	Тоо	0	1	1	1	100	100.00	100.00	Япон Удсын Газар, дэд бүтэц, тээвэр, аялал жуулчлалын яам 2025.05.16 №01/357
30	3.2.2	арга хэмжээ, сурталчилгаа	Тоо	0	5	5	5	100	100.00	100.00	
	3.3	Санхүү, тайлан, бүртгэлийг хууль тогтоомжийн нийцүүлэн явуулж, эд хөрөнгө, техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээг сайжруулах	Багц	0	3	3	3	100	100.00	100.00	2026 оны төсвийн төсөөлөлийн саналыг 2025.07.09 №01/55-аар ХББОСЯ-нд хүргүүлсэн
31	3.3.1	төсвийн төсөөлөл, санал	Тоо	0	1	1	1	100	100.00	100.00	Шилэн дансны цахим бүртгэл хөтөлсөн байна
32	3.3.2	оруулсан мэдээлэл	Тоо	0	1	1	1	100	100.00	100.00	2 удаа зохион байгуулсан
33	3.3.3	Тооллого Хүргүүлсэн мэдээлэл	Тоо	0	1	1	1	100	100.00	100.00	Umch.sgov.mn-д тулгалт хийсэн
34	3.3.4	Хугацаанд нь тайлагнасан тайлан Аудитын дүгнэлт	Тоо	0	4	4	4	100	100.00	100.00	Тайлангуудийг хуулийн хугацаанд тайлагнасан УАГ-аас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлан хэрэгжилтийг тайлагнасан байна
35	3.3.5	Батлагдсан төлөвлөгөө Төлөвлөгөөний хэрэгжилт	Тоо	0	1	1	1	100	100.00	100.00	2025.08.01 №А/21 ХАА-ны төлөвлөгөөг шинэчлэн баталсан ХАА-ны шалгаруулалт хийж гэрээ байгуулсан байна.
			%	0	100	100	100	БҮГД	75.36	83.14	

Засгийн газрын 2025 оны “Журам батлах тухай” 43 дугаар тогтоолын 3-р хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 2.4-т заасан аргачлалаар бодсон бөгөөд Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын 2.4.1, 2.4.2, 2.4.3 дахь заалтын дагуу боловсруулаагүй арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг арга хэмжээнд илүү холбоотой байх “шалгуур үзүүлэлт”, “зорилтод түвшин”-ийн аль нэгээр тооцож гаргасан болно.

Хэд хэдэн шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдсон арга хэмжээний биелэлтийн хувийг тодорхойлохдоо шалгуур үзүүлэлт бүрийн хэрэгжилтийг гарган тэдгээрийн архиметик дундажаар тооцож үнэлэв.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 35 арга хэмжээнээс жилийн эцсийн байдлаар хэрэгжилт 70 хүртэл хувьтай “Хангалтгүй” хэрэгжсэн 10 арга хэмжээ байна. Үүнд:

1. “1.1.1. Хот байгуулалтын эрх зүйн орчны судалгаа хийж “20 МИНУТЫН ХОТ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ”-ын төслийг боловсруулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран гүйцэтгэнэ.”
2. “1.1.3. Нийтийн тээврийн төрлүүдэд тавигдах шаардлага олон улсын норм, дүрэм, стандартыг судлан, Монгол Улсад нэвтрүүлэх талаар судалгаа хийх.”
3. “1.2.1. Бүтээн байгуулалтын төслүүдийн нэгдсэн менежментийн зөвлөх үйлчилгээний тендерт шалгарсан гүйцэтгэгчтэй чиг үүргийн дагуу хамтран ажиллана.”
4. “1.2.4. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй холбогдуулан боловсруулах Улаанбаатар хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулах”
5. “1.2.8. Нийгмийн үйлчилгээний хүрээнд сургууль цэцэрлэгийн чанар, хүртээмжийн судалгаа хийж, 2026 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барих сургууль цэцэрлэгийн тоог боловсруулах.”
6. “1.2.12. Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймгийн ерөнхий архитекторуудтай хамтран орон нутгийн зэрэглэлтэй хотуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах.”
7. “1.3.1. Бүтээн байгуулалтын төслүүдийн нэгдсэн менежментийн зөвлөх үйлчилгээ /Улаанбаатар/;
8. “2.1.1. 20 минутын хотыг олон нийт, хөрөнгө оруулагчдад сурталчилан таниулах зорилгоор контент бүтээх төслийг эхлүүлэх.”
9. “3.1.1. Байгууллагын үйл ажиллагааны стратеги төлөвлөлт, дотоод үйл ажиллагааны удирдлага, хяналтын системийг боловсронгуй болгох”
10. “3.1.4. Архив, албан хэрэг хөтлөлтийн журам боловсруулж батлуулах, архивын сан хөмрөг үүсгэх”

Мөн 1.2.10-т заасан “Агаарын болон хөрсний бохирдол, хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хог хаягдлыг ялгах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах хэрэгжилтийг судлалгаа дүгнэлт гаргах,



иргэд, байгууллагуудтай хамтран ажиллах” арга хэмжээ нь засгийн газар шинээр эмхлэн зохион байгуулагдсантай холбоотойгоор эрхлэх асуудлаас гарсантай холбоотойгоор үнэлгээнээс хасаж тооцсон.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ:

1. Хөгжлийн төвөөс хэрэгжилтээ 83.14 хувьтай үнэлж ирүүлсэн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд “Хангалттай” буюу **76.81** хувьтай үнэлэгдэж байна.

2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний арга хэмжээнүүдийн хэрэгжүүлэх хугацааг оны эхнээс эхлэн тасралтгүй үргэлжлэн улирал, хагас жил, бүтэн жилийн хугацаанд гүйцэтгэхээр баталсан байгаа нь ажлуудыг зөв хуваарилагдахгүй байх, зарим арга хэмжээг хэрэгжүүлж дууссаны дараа үргэлжлүүлэн хэрэгжүүлж эхлэх арга хэмжээ нь хэрэгжүүлэх цаг хугацаагүй гаргах боломжгүй нөхцөлүүдийг үүсгэсэн байна.

3. Хөгжлийн төвийн захиалагчийн хяналт хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээнд хэрхэн захиалагчийн хяналт хийсэн, ямар үр дүнд хүрсэн нь тодорхойгүй байгаа нь захиалагчийн хяналт хийх арга зүй байхгүйг харуулж байна. Захиалагчийн хяналт нь улсын төсвийг үр дүнтэй болгох чухал арга хэмжээ юм.

4. “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам” Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталж 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэнтэй холбоотой тус журмын 2.3, 2.4-т заасан аргачлалаар Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэхэд төлөвлөгөөнд заасан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтод түвшин нь хоорондоо утга, илэрхийлэл зөрүүтэй, тоон болон чанараар илэрхийлсэн хэмжих нэгж зөрүүтэй, эсвэл тодорхой хэмжих утга байхгүй, суурь түвшнээс ямар хэмжээнд нэмэгдүүлэх, ямар үр дүнд хүрэх нь тодорхойгүй, оновчтой тусгаагүй,

5. Хөгжлийн төвийн гүйцэтгэсэн голлох зарим ажлууд нь гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэд хэдэн арга хэмжээний хэрэгжилтэд тайлагнадсан байгаа нь хөгжлийн төвийн үйл ажиллагаа хэт чамлалттай байна.

6. Арга хэмжээнд судалгаа, зураг төсөл гаргахаар заасан, бусад орны норм, дүрмийг судлан санал боловсруулах зэрэг ажлуудын ирүүлсэн нотлох баримт нь танилцуулгаар байгаа нь тус ажлууд үнэн зөв, бодитой тооцоо судалгаа хийсэн эсэх, ямар арга аргачлалаар бодогдсон, хэн гүйцэтгэсэн зэрэг тодорхойгүй, судалгааны болон техникийн баримт бичиг гаргаагүй байна.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

20 минутын хот хөгжлийн төвийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээгээр дараах зөвлөмжийг гаргав. Үүнд:

1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө боловсруулахдаа ЗГ-ын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-д заасан аргачлалаар хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг хагас, бүтэн жил (Арга хэмжээг хэрэгжүүлэх хугацааг гүйцэтгэх ажлын дараалалаас хамааруулан сараар тодорхойлон тусгах, бүтэн жилийн хугацаа заахгүй байх)-ээр цаг хугацааг зөв төлөвлөж, хүрэх буюу зорилтот түвшин, суурь түвшинг хэмжиж болохуйц тоогоор илэрхийлж, төлөвлөгөөндөө тусгах; (ЗГ-ын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-д заасан аргачлалаар үнэлэх боломж, нөхцөлийг хангасан байх)



2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний “Хангалтгүй” гэж үнэлэгдсэн арга хэмжээнүүдийн биелэлтийг хангах;
3. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудалд хамаарах бүрэн дуусаагүй, цаашид үргэлжлүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дахин тусгаж хэрэгжилтийг бүрэн хангуулах арга хэмжээг авах;
4. Захиалагчийн хяналтыг үр дүнтэй болгоход анхаарч, захиалагчийн хяналт хэрэгжүүлэх үе бүрт баримт гаргах, үе шат бүрээр захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн тайлан гаргах, захиалагчийн хяналтаар илэрсэн алдаа зөрчил, зөвлөмжийн хэрэгжилтийг хянах, хангуулах тогтолцоог бүрдүүлэх,
5. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд хийгдэж байгаа судалгаа, ерөнхийлсөн ТЭЗҮ, төлөвлөлтийн төсөөлөл боловсруулах, санал дэвшүүлэх ажлуудыг үр дүнтэй ажил болгоход анхаарч, тодорхой арга аргачлаар гүйцэтгэх, тайлагнах, нотлох баримттай тайлагнах загварыг гарган баталгаажуулж үнэлэх, баримтжуулах,
6. Байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд албан хаагч бүр 1-ээс доошгүй судалгаа, төлөвлөлтийн шинэлэг үр дүнтэй ажлыг оруулан тусгах, хэрэгжилтийг хангуулахад анхаарч ажиллах, Жишээлбэл: “Хот суурин газрын төлөвлөгөөний баримт бичгийн хэрэгжилтийг үнэлэх”, “төлөвлөлтийн баримт бичгийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний загвар гаргах”, “Хот байгуулалтын кадастрын систем, Газар зохион байгуулалт хот төлөвлөлтийн цахим системийн хэрэглээний үнэлгээ”, “хот байгуулалт, төлөвлөлтийн үйл ажиллагааны дүрэм, журам, норм, стандартын хэрэгжилтийн үнэлгээ” гэх мэт.
7. Судалгааны ажилд орон зайн байршил, хүн ам, нийгэм эдийн засаг болон бусад хүчин зүйлсийг цогцоор нь оруулж үр дүнг бодитой гаргахад анхаарах,
8. Тайлагналтыг товч тодорхой, 2000 тэмдэгтэд багтаан тайлагнаж байх,
9. Судалгаа, загвар төслүүдийн тайлагналтыг нотлох баримттай, техникийн, шинжлэх ухааны болон албан хэрэг хөтлөлтийн стандартад нийцсэн баримтаар гаргаж байх;

Тайланг хянасан:

СХШҮДАГ-ын даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч

Б.Найрамдал

Боловсруулсан:

СХШҮДАГ-ын шинжээч

Б.Одбаатар